



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/28

Мандалговь

Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл,
Залуучуудын хөгжлийн зөвлөлийн гишүүдэд
сургалт зохион байгуулах тухай

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төсвийн ерөнхийлөн захирагчаас Төсвийн шууд захирагчтай байгуулсан 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.1.1, 1.1.7, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 01/239 дугаар албан тоотыг үндэслэн тус тус ТУШААХ нь:

1. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн гишүүдийн үйл ажиллагааг чадавхжуулах, зөвлөлийн гишүүдийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгуулсугай.

2. Үйл ажиллагаа зохион байгуулах ажлын хэсгийг 1 дүгээр, төсвийг 2 дугаар, хавсралтаар тус тус баталсугай.

3. Үйл ажиллагаа зохион байгуулахад шаардагдах 67,260 (Жаран долоон мянга хоёр зуу) төгрөгийн зардлыг Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтийг хангаж, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн ажлын албаны нарийн бичиг, ажлын хэсгийн ахлагч (Х.Төмөрбат)-д үүрэг болгосугай.

5. Үйл ажиллагааны хэрэгжилтэнд хяналт тавьж үр дүнг 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Х.Төмөрбат)-д даалгасугай.


ДАРГА



Ц.ГАНЗОРИГ

№ 482201055

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,
залуучуудын хөгжлийн газрын даргын
2022 оны 04 дугаар сарын 04 ний өдрийн
0128 дугаар тушаалын 02 дугаар хавсралт



ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ,ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙГ ИДЭВХЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Х.Төмөрбат

(Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн
ажлын албаны нарийн бичиг)

Гишүүд:

Р.Мөнхбат

(Захиргаа, хүний нөөц хариуцсан ахлах
мэргэжилтэн)

Ш.Эрдэнэсүвд

(Хүүхдийн эрхийн улсын байцаагч)

Б.Мөнх-Оргил

(Архив, бичиг хэрэг)

Л.Цэвэлмаа

(Нярав)

—oOo—

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,
залуучуудын хөгжлийн газрын даргын
2022 оны 04 дугаар сарын 15 ний өдрийн
1128 дугаар тушаалын 0.9 дугаар хавсралт

ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ,ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙГИДЭВХЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
ТӨСВИЙН ТООЦООЛОЛ

№	Материалын нэр	Тоо	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Цэвэр ус	38	ш	680	25,840
2	1 удаагийн аяга	38	ш	90	3,420
3	Бичгийн цаас	2	Боодол	19,000	38,000
Нийт дүн					67,260

---oOo---